



ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН 2024 ОНЫ БҮРДҮҮЛЭЛТ,
ЗАРЦУУЛАЛТ, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ”

ЭРХ БҮХИЙ БАЙГУУЛЛАГУУД ХЯНАЛТЫН
ЧИГ ҮҮРГЭЭ ХАНГАЛТГҮЙ ХЭРЭГЖҮҮЛСНЭЭС ЗӨРЧИЛ
ДАВТАГДАН ГАРСААР БАЙНА

Аудитын код: ДГА-2025/31-8-ШТА-ГА

Цахим хуудас: www.audit.mn Дорноговь аймаг 2025 оны 07 сар	Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий	
	Утас: 70522734	Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
	Аудитын менежер:	У.Оюунтүлхүүр
	Утас: 70523020	Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn
	Ахлах аудитор:	О.Нарангарав
Аудитор:		Цахим хаяг: Narangarav.o@audit.gov.mn
	Аудитор:	Т.Мөнхтогтох
		Цахим хаяг: Munkhtogtokht@audit.gov.mn
Аудитор:		Н.Мөнхнасан
		Цахим хаяг: Munkhnasann@audit.gov.mn
Аудитор:		А.Дамчой
		Цахим хаяг: damchoia@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Аудитын зорилт, хамарсан хүрээ, стандарт, арга зүйн талаарх мэдэгдэл

Аудитын харилцан хамаарал	Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын сэдэв батлах тухай” 2024 оны А/107 дугаар тушаал, “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2024 оны А/108, Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын дарга тэргүүлэх аудиторов “2025 онд гүйцэтгэх гүйцэтгэл, нийцлийн аудитын жилийн төлөвлөгөөг батлах тухай” 2025 оны А/12 дугаар тушаалуудыг тус тус үндэслэн хийж гүйцэтгэв.
Аудитын зорилго, зорилтууд	“Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр дүн, үр нөлөө”-т байдалд гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт, зөвлөмж гарган, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулж, олон нийтэд мэдээлэхэд аудитын зорилго чиглэгдэв. Дээрх зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэлээ. Үүнд: - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг холбогдох хууль журамд заасны дагуу төлөвлөж, бүрдүүлж, хуваарилсан эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг журмын дагуу үр дүн, үр нөлөөтэй хэрэгжүүлсэн эсэх; - Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтыг хууль журмын дагуу хянаж, тайлагнасан эсэх асуудлыг тус тус хамруулна.
Аудитын хамрах хүрээ	Орон нутгийн хөгжлийн сангийн 2024 оны орлогын бүрдүүлэлт, хуваарилалт болон хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл, санхүүжилт, хяналт, тайлагналтай холбоотой үйл ажиллагааг хийж хэрэгжүүлдэг аймаг, сумын ИТХ, ЗДТГ, СТСХ, БОНХОБТХ, аймгийн Худалдан авах ажиллагааны газар, Орон нутгийн өмчийн газар, ГХБХБГ зэрэг байгууллагуудыг хамруулан аудитыг хийж гүйцэтгэлээ.
Аудит хийхэд гарсан хүндрэл бэрхшээл	Цаг хугацааны хязгаарлалтаас сумдад хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, ашиглалтын байдлыг газар дээр нь очиж үзэх боломжгүй болж, холбогдох ажилтнуудтай утсаар мэдээлэл солилцон, тайлбар тодруулга авч, ТАХ-ний гүйцэтгэлийн зургийг цахимаар авч, аудитыг баримтад үндэслэн хийж гүйцэтгэлээ.

БҮЛЭГ 1. ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН САНХҮҮЖИЛТИЙН ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРЭН ТӨВЛӨРҮҮЛЭН АЖИЛЛАХ ТАЛААР САНААЧИЛГАТАЙ АЖИЛЛААГҮЙГЭЭС 4,429.9 САЯ ТӨГРӨГИЙН ДУТУУ САНХҮҮЖИЛТТЭЙ АЖИЛЛАСАН БАЙНА.

1.1 Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн эх үүсвэрийн санхүүжилтийг хууль, журамд заасны дагуу тооцож төлөвлөсөн боловч 1,855.9 сая төгрөгийг дутуу олгосон байна.

1.1.1 ОНХНС-аас аймгийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хууль, журмаар баталсан аргачлалын дагуу хуваарилж баталсан боловч санхүүжилтийг дутуу олгосон байна.

ОНХНС-аас аймагт нийт 42,708.1 сая төгрөгийн санхүүжилтийг олгохоос 40,852.2 сая төгрөгийн санхүүжилтийг олгож, батлагдсан төсвөөс **1,855.9 сая төгрөгийн шилжүүлгийг** дутуу олгосон байна.

1.1.2 Аймгийн ОНХС-аас сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 8 суманд батлагдсан хуваариас дутуу санхүүжүүлсэн байна.

ОНХНС-аас олгосон ОНХС-ийн шилжүүлгийг аймгийн СТСХ, БОНХОБТХ аймаг, сумдын хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний гүйцэтгэлд үндэслэн аймгийн ОНХС-д 17,250.6 сая төгрөгийн, сумдын ОНХС-д 8,320.8 сая төгрөгийн шилжүүлгийг тус тус олгосон байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн 2021-2024 оны орлогын шилжүүлгийг харьцуулалт хийхэд жил бүр өссөн үзүүлэлттэй бөгөөд сүүлийн 2 жилд 47-52 хувиар өссөн байна.

1.1.3 Өмнө оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг үйл ажиллагааны орлогоор баталснаас орлогын төлөвлөгөө 1,636.0 сая төгрөгөөр тасарсан байна.

Орон нутгийн татварын орлого

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2.4-т заасан эх үүсвэрийг 3 сум 2,428.0 сая төгрөгөөр төлөвлөж, гүйцэтгэлээр 1,617.4 сая төгрөг хуваарилан, биелэлт 66.6 хувьтай байна.

Гадаад, дотоодын хандив,

Гэрээний заалтын дагуу тайлант онд аймгийн ОНХС-д 236.4.0 сая төгрөгийн хандив тусламжийн орлогыг бүрдүүлэхээр төлөвлөж, “Смарт ойл Монголиа” ХХК 203.2 сая төгрөг, “Доншен газрын тос Монгол” ХХК 30.0 сая төгрөг, нийт 233.2 сая төгрөгийн хандивыг төвлөрүүлж биелэлт 98.6 хувьтай байна.

Малын тоо толгойн албан татвар

Тайлант онд 9 сум МТТАТ-ын орлогыг төлөвлөснөөс 3 сум орлогыг 0.4-2.3 сая төгрөгөөр давуулан биелүүлж, 6 сумын орлого 1.7-153.4 сая төгрөгөөр тасарсан байна.

Сангийн өмнөх оны зарцуулагдаагүй үлдэгдэл

Сумдын ИТХ-аар 2023 оны зарцуулагдаагүй үлдэгдлээс нийт 1,491.4 сая төгрөгийг санхүүжүүлэхээр баталсан бөгөөд гүйцэтгэлээр нийт 518.8 сая төгрөгийг зарцуулсан байна.

1.2 ОНХС-аар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь санал өгсөн иргэдийн 90 хувийн саналаар дэмжигдсэн, богино хугацааны бодлогын баримт бичигт тусгагдсан ажлуудыг төлөвлөсөн байна.

1.2.1 Аймгийн хэмжээний 14 сум 65 багийн санал өгөх боломжтой иргэдээс 19 хувь нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөгөөнд санал өгсөн байна.

Аймаг, сумдын ИТХ-аар иргэдийн саналаар дэмжигдсэн 43,473.9 сая төгрөгийн 178 ТАХ, дэмжигдээгүй 2,122.6 сая төгрөгийн 20 ТАХ батлагдсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэх ТАХ-ний төлөвлөлтөд 14 сумын 65 багийн 21,453 өрхийн хуралдаанд оролцох боломжтой насанд хүрсэн 45,557 иргэдийн 19 хувь буюу 8,659 иргэн санал өгсөн байна.

1.2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ орон нутгийн дунд болон богино хугацааны бодлогын баримт бичигтэй уялдсан байна.

Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд шинээр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн 198 ТАХ нь аймгийн урт, дунд болон богино хугацааны хөгжлийн бодлогын баримт бичгүүдтэй бүрэн уялдуулсан байна. Тухайлбал нийт ТАХ-ний 50.0 хувь нь хувь хүний хөгжил, 21.0 хувь нь орон нутгийн хөгжил, 13.0 хувь нь эдийн засаг, 7.0 хувь нь амьдралын чанар ба дундаж давхарга, 5.0 хувь нь амар тайван аюулгүй нийгэм, 5.0 хувь ногоон хөгжил зорилтыг хангахад тус тус чиглэсэн байна.

1.2.3 Сумдын ИТХ-ын хурлаар техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөвгүй баталсан 706.5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг баталсан байна.

Сумдын ИТХ-ын хуралдаанаар ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг батлахдаа техник, эдийн засгийн үндэслэл хийгдээгүй, зураг төсөв батлуулаагүй 706.5 сая төгрөгийн 4 төсөл, арга хэмжээг баталсан байна. Тухайлбал:

- Даланжаргалан сум: “Тэгш гудамж, зам дагуу байрлалтай айл өрхийн хашааны өнгө үзэмжийг сайжруулах ажил” 49.9 сая төгрөг,
- Иххэт сум: “Наадмын талбайн тохижилтын ажил” 186.6 сая төгрөг,
- Сайншанд сум: “Өвс тэжээлийн агуулах барих ажил” 440.0 сая төгрөг, “Газар тариалангийн бусад ЦДАШ татах ажил” 30.0 сая төгрөг зэрэг байна.

1.2.4 Аймаг, сумдад ОНХС-аар хэрэгжүүлэхээр баталсан төсөл, арга хэмжээ нь тухайн шатны Засаг даргын чиг үүрэгтэй уялдаж байна.

- Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр нийт 25 ТАХ-г төлөвлөсөн нь журамд заасан чиг үүрэгтэй нийцэж байгаа бөгөөд 44.0 хувь буюу 11 ТАХ нь “Орчны тохижилт, ногоон байгууламж, байгаль орчныг хамгаалах, 36.0 хувь буюу 9 ТАХ нь “Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ”, 20.0 хувь буюу 5 ТАХ нь “Иргэдийн эрүүл мэндийг хамгаалах, боловсрол, соёл, Инновац, шинжлэн ухаан, цахим технологи” чиг үүргийг хэрэгжүүлэхээр төлөвлөгдсөн бөгөөд нийт ТАХ-ний 12.6 хувийг эзэлж байна.
- Сумдын ОНХС-ийн хөрөнгөөр нийт 173 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 49.1 хувь буюу 85 ТАХ нь “Орчны тохижилт, ногоон байгууламжийг сайжруулах, байгаль орчныг хамгаалах”, 19.7 хувь буюу 34 ТАХ нь “Малын тоо толгойн албан татвараар хэрэгжүүлэх ажил”, 11.6 буюу 20 ТАХ нь “Дэд бүтцийг сайжруулах, зам гүүр, далан шуудуу, цахилгаан, дулааны шугам сүлжээ”, 19.6 хувь буюу 34 ТАХ нь журамд заасан бусад чиг үүргийн дагуу төлөвлөгдсөн бөгөөд нийт ТАХ-ний 87.4 хувийг эзэлж байна

БҮЛЭГ 2. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн тэнцвэртэй байдлыг хангаж, иргэдийн тогтвор суурьшилтай амьдрах орчин, нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэгдсэн байна

2.1 Аймаг, сумын ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний 38.4 хувьд шууд худалдан авалт хийсэн байна.

2.1.1 Аймаг, сумын ИТХ-аар батлагдсан 183 ТАХ-д холбогдох журмын дагуу худалдан авах ажиллагааг зохион байгуулж, 172 ТАХ-г хэрэгжүүлэхээр гэрээг байгуулсан байна.

Аймаг, сумдын ИТХ-аар тайлант онд шинээр хэрэгжүүлэхээр батлагдсан 45,596.5 сая төгрөгийн 198 ТАХ-ний 44,482.1 сая төгрөгийн 184 ТАХ-нд сонгон шалгаруулалтыг зохион байгуулж 172 ТАХ-д 51,710.9 сая төгрөгийн ажил гүйцэтгэх гэрээг байгуулж, 747.4 сая төгрөгийн 12 ТАХ-ний сонгон шалгаруулалт амжилтгүй болж батлагдсан төсөв хэмнэлтээр үлдсэн байна.

Нийт шалгарсан тендерээс нээлттэй сонгон шалгаруулалтын аргаар 40,339.8 сая төгрөгийн 61, харьцуулалтын аргаар 2,967.6 сая төгрөгийн 50, гэрээ шууд байгуулах аргаар 1,174.7 сая төгрөгийн 73 ТАХ-г тус тус зохион байгуулсан байна.

2.1.2 ОНХС-ийн санхүүжилтийг ТАХ-ний бодит гүйцэтгэлд үндэслэн олгосон байна.

Тайлант онд нийт 194 ТАХ-ний 42,016.0 сая төгрөгийн санхүүжилтийг гүйцэтгэлд үндэслэн олгосон бөгөөд 85.9 хувийн биелэлттэй тайлагнагдсан байна.

Тайлант онд өмнө оноос шилжиж ирсэн, санхүүжилтийн үлдэгдэл дутуу **27 ТАХ-д** 3,390.0 сая төгрөгийн төсөв батлагдаж, **31 ТАХ-д** гүйцэтгэлээр 2,974.1 сая төгрөгийг зарцуулсны сумдын ИТХ-аар батлагдаагүй 8 ТАХ-д 191.0 сая төгрөгийг зарцуулсан байна.

Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.3¹, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.7.2²-т зааны дагуу Үндэсний их баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэх зардалд Алтанширээ сумын ОНХС 19.6 сая төгрөгийг, Даланжаргалан сумын ОНХС 18.7 сая төгрөгийг, Сайхандулаан сумын ОНХС 20.0 сая төгрөгийг тус тус Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээ 5.0 сая төгрөг хэтрүүлэн зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 6.4.1³, “Наадмын санхүүжилт, жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын холбогдох заалттай нийцэхгүй байна. Аудитаар Алтанширээ, Сайхандулаан сумдын Засаг дарга нарт алдаа зөрчлийг таслан зогсоох, цаашид давтан гаргахгүй байх албан шаардлагыг хүргүүлээ.

¹ Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг дараах зүйлд зарцуулахыг хориглоно: үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал

² Энэ зүйлийн 4.6-д зааснаар ОНХС-ийн хөрөнгийг зарцуулах зөвшөөрөхгүй зардалд дараах хамаарах ба үүгээр хязгаарлагдахгүй: Үндэсний их баяр наадмаас бусад баяр, наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн ёслолын зардал;

³ Энэ хуулийн 5.1.3-т заасан санхүү, төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг дараах байдлаар хэрэгжүүлнэ: төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;

Айраг сумын ОНХС-аас 2023 онд хэрэгжсэн “ЕБС-ийн дээврийн засвар”, ажлын баталгааны санхүүжилтийг гүйцэтгэгч байгууллагуудад олгохдоо 3.7 сая төгрөгийг гэрээний үнийн дүнгээс илүү шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.6⁴, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 3.4.3⁵-т заасантай тус тус нийцэхгүй байна.

Аудитаар Айраг сумын Засаг даргад илүү шилжүүлсэн санхүүжилтийг холбогдох байгууллагаар нөхөн төлүүлэх төлбөрийн акт тогтоон хүргүүллээ.

2.2 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-нь иргэдэд хүрсэн үр нөлөөтэй ажлууд байна.

2.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ төлөвлөсөн зорилтот түвшинд хүрсэн, үр дүнтэй арга хэмжээнүүд байна.

Аймаг, сумын ИТХ-аар 2024 онд нийт 48,937.6 сая төгрөгийн 225 ТАХ-г ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр баталсны 21,471.6 сая төгрөгийн 175 ТАХ-г бүрэн хэрэгжүүлж, 25,409.8 сая төгрөгийн 20 ТАХ-г дутуу хэрэгжүүлэн, 2,056.2 сая төгрөгийн 30 ТАХ огт хэрэгжүүлээгүй байна.

Аудитаар Даланжаргалан сумын “Цомог багийн гэр бүлийн талбайн тохижилтын ажил”, Дэлгэрэх сумын “Хогийн цэгийн салхин доод талд хамгаалалтын торон хашаа” хийх ажлуудыг хэрэгжүүлж дуусгах албан шаардлагыг сумдын Засаг дарга нарт хүргүүллээ.

2.2.2 Аймаг, сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн арга хэмжээ нь тухайн орон нутгийн хөгжилд бодит хувь нэмэр оруулах, иргэдийн эрүүл мэнд, амьдрах ая тухтай орчныг сайжруулахад чиглэгдсэн байна.

Монгол улсын 330 сумаас анх удаа Замын-Үүд суманд “Цусны салбар банк буюу цусны төв” нээгдэж цус алдсан, цус багадалттай хүнд түргэн, шуурхай цус бэлтгэн сэлбэлт хийх, цусны бүлэг, хувийн тохироо тодорхойлох шинжилгээ зэргийг хийж, сумын Нэгдсэн эмнэлгийн цусны салбар төвийн тусламж үйлчилгээ үзүүлэх чанар хүртээмж нэмэгдэх боломж бүрдэж иргэдийн эрүүл мэндэд чиглэсэн үр нөлөөтэй томоохон ажлын нэг болж чадсан байна.

Сумдын төвд хийгдсэн цэвэр, бохир дулааны шугамд холбох, төрийн албан хаагчийг орон сууцаар хангах, сургууль цэцэрлэгийн барилгад засвар үйлчилгээ хийх зэрэг томоохон ажлууд нь иргэдийг хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажиллах, орон нутгийг тэнцвэртэйгээр хөгжүүлэх нөхцөлийг бүрдүүлж байна.

2.3 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон төсөл арга хэмжээг ашиглагч байгууллагад шилжүүлснээр хөрөнгийг ашиглах, хадгалах, хамгаалах нөхцөлийг бүрэн бүрдүүлсэн байна.

2.3.1 ОНХС-ийн санхүүжилтээр бий болсон хөрөнгийг зориулалтын дагуу ашиглаж байна.

⁴ төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр худалдан авах бараа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлийн санхүүжилтийг бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны гэрээ, төлбөрийн хуваарийг үндэслэн санхүүжүүлэх

⁵ Сум, дүүргийн хэмжээнд ОНХС-ийн үйл ажиллагааг зохион байгуулах, хэрэгжилтэд хяналт тавих

Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-г холбогдох тушаал шийдвэр, захирамжийн дагуу ашиглагч байгууллагад шилжүүлсэн байна.

Аудитын явцад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн аймгийн төвийн 13 ТАХ, Сайншанд сумын 7 ТАХ, Өргөн сумын 9 ТАХ, нийт 29 ТАХ-ний хөрөнгийн ашиглалтын байдлыг газар дээр нь очиж үзсэн.

Аудитаар Сайншанд сумын ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон 104 камерын ажиллаж байгаа эсэхэд тулгалт хийхэд 13 камер ажиллагаагүй байсан бөгөөд камерыг засварлуулах, ашиглалтад оруулж зөрчлийг арилгах албан шаардлагыг Сайншанд сумын Засаг даргад хүргүүлээ.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1⁶-д заасантай нийцэхгүй байгаа тул аймгийн БТСГ-т бүртгэлжүүлэн хүлээлгэн өгч иргэд олон нийтэд ашиглуулах тухай албан шаардлагыг Сайншанд сумын Засаг даргад хүргүүлээ.

“Сайншанд сумын ЕБ-ын 1 дүгээр сургуулийн их засвар” ажлаар хийсэн 34 анги, гурван 00-ын өрөөний хаалганы цоож, бэхэлгээ, 22 анги, гурван 00-ын өрөөний амлагаа эвдэрч муудсан, сургуулийн гал тогооны өрөөний агааржуулагчийн мотор, дотор засвар, голын хаалга, хаалганы түгжээ, агааржуулалтын нүх, ерөнхий газардуулга, ерөнхий шит, дээврийн аянгын хүрээний газардуулга, гал тогооны газардуулга зэргийг ажлуудын засвар хангалтгүй хийгдсэн, “ЕБ-ын 1 дүгээр сургуулийн биеийн тамирын талбайг шинэчлэх” ажлаар хийсэн тоглоомын талбайн 2 тоглоом эвдрэлтэй хүүхдүүд тоглох боломжгүй байна.

Аудитаар эвдрэл гэмтэлтэй ажлуудыг Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.6⁷-д заасны дагуу засварлуулахаар Аймгийн Засаг даргад албан шаардлага хүргүүлээ.

2.3.2 ОНХС-ийн хийсэн эзэмшигч, ашиглагч байгууллагад шилжсэн хөрөнгийн хадгалалт, хамгаалалтыг хууль журмын дагуу хэрэгжүүлж байна.

Аймаг, сумын ОНХС-аар хэрэгжүүлсэн томоохон ТАХ-ны арга хэмжээний хадгалалт, хамгаалалттай түүвэрлэн танилцахад хэвийн, хангалттай байна. Тухайлбал:

- Мандах сум – Сумын төвийн айл өрхийн жишиг хашааны хаалганы ажил;
- Өргөн сум – Сумын төвд нийтийн бие засах газар байгуулах;
- Улаанбадрах сум – Сангийн далай багт "Мал угаалгын ванн" байгуулах;
- Сайншанд сум – 2 дугаар Саруул хотхонд хүүхдийн тоглоомын талбай байгуулах;
- Дорноговь аймаг – Аймгийн Ерөнхий боловсролын сургуулиудад гадна, дотор камер худалдан авах ажил.

Харин Сайншанд сумын 2 дугаар багийн 618, 620 дугаар байрны гадна талын хүүхдийн тоглоомын талбайд суурилуулсан 3ш гудамжны гэрэлтүүлэг цахилгаан эрчим хүчний хуваарилалт дутуу буюу тогны паззаас шалтгаалж гэрэлтүүлгийн тусгал муу бүдэг байна.

Аймаг, сумын ОНХС-аар хийгдсэн хөрөнгийн хадгалалт хамгаалалт зохистой, хэвийн байна.

⁶ Төрийн өмчийн эд хөрөнгийг эрх бүхий байгууллагын шийдвэрээр төр, хувийн хэвшлийн түншлэлийн болон түрээсийн гэрээгээр, мөн хуулиар зөвшөөрсөн бол үнэ төлбөргүйгээр бусдад эзэмшүүлж, ашиглуулж болно.

⁷ Энэ хуулийн 14.3-т заасан хугацаа дуусгавар болсноос хойш барилга байгууламжийн гадна, дотор засал, бүх төрлийн материал, үндсэн хийц, бүтээц, цэвэр, бохир ус, уур, хий, дулаан, цахилгаан, харилцаа холбооны тоног төхөөрөмж, тоноглолын хэвийн ашиглалтын хугацаа гурваас доошгүй жил байна.

БҮЛЭГ 3. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хяналт тавьж, тайлагнах ажлыг аймаг болон зарим сумд хууль журмын дагуу бүрэн хэрэгжүүлээгүй байна.

3.1. ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалт, төсөл арга хэмжээний гүйцэтгэлд аймаг, сумын ИТХ болон захиргааны байгууллагаас тавих хяналт хангалтгүй байна.

3.1.1 Аймаг, сумдын ИТХ-аас ОНХС-ийн журамд заасан хяналтыг тавьж ажилласан гэх боловч тайлагналт хангалтгүй байна.

Аймаг, болон 12 сумдын ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний гүйцэтгэлийн явц хэрэгжилтэд хяналт тавих хяналтын хороог томилж хяналтыг хэрэгжүүлсэн бөгөөд тэдгээрийн ажлын тайлантай танилцан, нэгтгэн авч үзэхэд тайлант онд шинээр хэрэгжүүлж байгаа 198 ТАХ-ний 135 ТАХ буюу 68.4 хувьд нь хяналтыг хэрэгжүүлэн, 63 ТАХ буюу 33.3 хувьд нь хяналтыг хэрэгжүүлээгүй байна.

Тайлант онд Хөвсгөл сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн 5 ТАХ, Дэлгэрэх сумын 15 ТАХ-д сумын ИТХ-аас хяналтыг огт тавиагүй байна.

Аудитаар журамд заасны дагуу сумын хэмжээнд хэрэгжиж байгаа ТАХ-д хяналт хэрэгжүүлэх хяналтын хороог байгуулан гишүүдийг арга зүйгээр хангах, тайлан мэдээг тухай бүр авч хяналтыг хэрэгжүүлж ажиллах талаар Дэлгэрэх, Хөвсгөл ИТХ-ийн дарга нарт зөвлөмжийг хүргүүлээ.

3.1.2. Захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх шаардлагатай байна.

Мэргэжлийн байгууллагаар захиалагчийн хяналт хийлгэхгүй байх нь тухайн төсөл арга хэмжээ чанаргүй, зураг төсвийн дагуу гүйцэтгэхгүй байх эрсдэлийг үүсгэж хөрөнгийн зарцуулалт үр дүнгүй болоход нөлөөлөх эрсдэлтэй байна.

Иймээс төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд холбогдох заавар журмын дагуу захиалагчаас тавих хяналтыг сайжруулж хөрөнгийн үр дүнг дээшлүүлэхэд анхаарч ажиллах шаардлагатай байна.

3.1.3. Өмнөх аудитаар хүргүүлсэн шийдвэрийн хэрэгжилтийн тайланг ирүүлсэн боловч алдаа зөрчлүүд давтагдан гарсаар байна.

ҮАГ-ын нэгдсэн удирдамжаар “Орон нутгийн хөгжлийн сангийн 2023 оны бүрдүүлэлт, зарцуулалт, үр нөлөө, үр дүн” сэдэвт гүйцэтгэлийн аудитыг 2024 онд гүйцэтгэж нийт 830.0 сая төгрөгийн 10 албан шаардлага, 7 зөвлөмжийг холбогдох 10 албан тушаалтнуудад хүргүүлсэн бөгөөд 94.1 хувийн биелэлттэй байна.

Өмнөх аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийг холбогдох байгууллагууд хэрэгжүүлэн ажилласан эсэд аудитын явцад хяналтыг хэрэгжүүлэхэд ИТХ-аар батлуулаагүй ТАХ-ний санхүүжилтийг олгосон, ИТХ-аар төсөв батлуулахдаа техник, эдийн засгийн үндэслэлгүй ТАХ-ний төсөв батлуулсан, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ажлыг батлуулсан гэх мэт алдаа зөрчлүүд давтагдан гаргасаар байна.

Аймгийн Засаг даргад аймаг болон сумдын ОНХС-ийн Удирдлагын мэдээллийн системийн ашиглалтыг сайжруулах, байршуулсан мэдээллийн үнэн зөв иж бүрэн байдлыг хянаж арга зүйгээр хангаж системийн хэрэгжилтийг ханган ажиллуулахаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийн биелэлт хангалтгүй байна.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ТАХ-ний мэдээллийг журмын дагуу иргэд, олон нийтэд үнэн зөв иж бүрэн мэдээллийг хүргэх шаардлагатай байна.

3.2.1 ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн арга хэмжээг холбогдох журам, зааврын дагуу бүрэн тусгаж тайлагнаагүй байна.

Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь журмын 9.9-д заасны дагуу аймгийн ОНХС-ийн хэрэгжилтийн жилийн эцсийн тайланг нэгтгэн Сангийн яамны Төсвийн бодлого төлөвлөлтийн газарт 2025 оны 03 дугаар сарын 18-ны өдрийн 03/383 дугаар албан бичгээр хүргүүлсэн байна.

Аймгийн ЗДТГ-ын БОНХОБТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний тайлан, мэдээг сум бүрээс авч, дүгнэлт хийж, цаашид авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар нэгдсэн тайлан бэлтгэж гаргаагүй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний жилийн эцсийн тайланг журамд заасан заалтуудын мэдээллийг бүрэн тусган хуулийн хугацаанд хүргүүлэх зөвлөмж өгөхөөр шийдвэрлэв.

3.2.2. Данс бүртгэлд тусгах хөрөнгийн 97.4 хувийг нягтлан бодох бүртгэлд бүртгэсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн холбогдох байгууллагын нягтлан бодох бүртгэлд тусгах 196 ТАХ-ээс тайлант хугацаанд 191 ТАХ-г бүртгэж тайлагнасан байна.

3.2.3. Удирдлагын мэдээллийн системд мэдээллийг үнэн зөв, бүрэн оруулаагүйгээс иргэд олон нийт мэдээллийг тухай бүрд авч чадахгүй байна.

Аймаг сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх 225 ажлын системд оруулсан мэдээллийг шалгахад 26.2 хувь буюу 59 арга хэмжээний мэдээллийг үнэн зөв, 18.2 хувь буюу 41 ажлын мэдээлэл зөрүүтэй, журамд заасан хугацаанд оруулаагүй 55.5 хувь буюу 125 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй, байна.

3.2.4. Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, тушаал шийдвэрийг хугацаанд нь мэдээлээгүй, байршуулаагүй зөрчил бүрэн арилаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжсэн төсөл, арга хэмжээний шилэн дансны цахим системд байршуулсан мэдээллийг үзэхэд дараах байдалтай байна. Үүнд:

- Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ, түүний төлөвлөгөө, гүйцэтгэл, ХАА-ын мэдээлэл зэргийг аймаг болон 8 сум ОНХС хугацаанд нь үнэн зөв мэдээлсэн бол Даланжаргалан, Дэлгэрэх, Замын-Үүд, Хөвсгөл сумд батлагдсан ТАХ-г огт мэдээлээгүй, Иххэт, Эрдэнэ сумд нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний гүйцэтгэлийг шилэн дансны системд байршуулаагүй,
- Хөрөнгө мөнгө зарцуулах тушаал шийдвэр, 5.0 сая төгрөгөөс дээш зарлагын гүйлгээг аймгийн ОНХС болон Дэлгэрэх сумаас бусад сумд тушаал шийдвэр, гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Мэдээллийг оруулаагүй, хугацаа хоцроон байршуулсан зөрчилд ОНХС-ийн санхүүгийн тайлангийн аудитаар холбогдох албан тушаалтнуудад зөрчлийг арилгах давтан гаргахгүй байх 10 зөвлөмж, 1 албан шаардлагыг хүргүүлсэн байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

- ОНХНС-аас аймаг, сумдын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг батлагдсан аргачлалын дагуу тооцож гаргасан боловч 1,855.9 сая төгрөг дутуу олгосон байна.
- ОНХС-ийн орлогын эх үүсвэрийг төлөвлөхдөө гадаад, дотоодын хандив тусламжийн орлого, өмнөх оны үлдэгдэл, малын тоо толгойн татварын орлогыг санхүүжилтийн эх үүсвэрт тусгаж батлуулсан ч, зарим сумд мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл, орлогын шилжүүлгийн хуваарилсан төсвөөс хэтрүүлэн баталсан байна.
- Хөвсгөл сумын Засаг дарга орон нутагт үйл ажиллагаа явуулдаг ашиг малтмалын тусгай зөвшөөрөл эзэмшдэг компанитай нийгмийн хариуцлагын хүрээнд хамтран ажиллах гэрээ байгуулж ОНХС-ийн дансанд төвлөрүүлэх санхүүгийн дэмжлэгийг хувийн аж ахуй нэгжийн дансаар авахаар гэрээг байгуулсан байна.
- Сумдад ОНХС-ийн эх үүсвэрээр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө багийн иргэдээс санал авч ИНХ-аар хэлэлцүүлэх ажил хийгддэг ч зарим сумд иргэдээс санал авч эрэмбэлээгүй ажлыг ИТХ-аар батлуулж, санхүүжүүлсэн байна.
- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаж, тухайн шатны Засаг даргын хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарсан байна.
- Төсвийн тооцоолол хийгдээгүй, мэргэжлийн байгууллагын баталсан зураг төсөвгүй ТАХ-г тухайн сумын ИТХ нь баталж, дараа нь зураг, төсвийг хийлгэж байгаа зөрчил давтагдан гарсаар байна.
- Аймаг, сумдын ОНХС-ийн хөрөнгөөр 2024 онд нийт 48,986.4 сая төгрөгийн 225 ТАХ хэрэгжүүлэхээр төлөвлөж, 176 ТАХ бүрэн, 20 ТАХ дутуу, 29 ТАХ-г огт хэрэгжүүлээгүй, нийт гүйцэтгэл 85.1 хувьтай байна.
- Зарим сумд ИТХ-аар батлагдаагүй 11 ТАХ-д 230.7 сая төгрөгийн санхүүжилт олгосонд санхүүгийн тайлангийн аудитаар 7 зөрчлийг шийдвэрлэж, холбогдох албан тушаалтанд аудитын шийдвэрийг өгсөн байна.
- Монгол Улсын 330 сумаас анх удаа Замын-Үүд суманд "Цусны салбар банк" нээгдэж, цусны төвийн тусламж үйлчилгээ орон нутагт түргэн шуурхай үзүүлэх боломж бүрдэж байгаа нь иргэдийн эрүүл мэндэд чиглэсэн үр дүнтэй томоохон ажлын нэг болж чадсан байна.
- Тухайн шатны ИТХ-аас ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх, хөтөлбөр, ТАХ-ний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлд хяналт хэрэгжүүлэх хороодыг томилсон ч төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн үе шатанд хэрэгжүүлсэн хяналт тодорхой бус хангалтгүй байна.
- Сангийн яамд хүргүүлсэн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн ажлын жилийн нэгтгэл тайланд журамд заагдсан мэдээллүүд бүрэн тусгагдаагүй байна.
- Сангийн хөрөнгөөр хэрэгжсэн хөрөнгө оруулалтын ажлын 97.4 хувийг НББ-д тусгасан байна.
- Удирдлагын мэдээллийн системд нийт ТАХ-ны 26.2 хувь буюу 59 арга хэмжээний мэдээллийг үнэн зөв, 18.2 хувь буюу 41 ажлын мэдээлэл зөрүүтэй, 55.5 хувь буюу 125 ТАХ-ний мэдээллийг огт оруулаагүй байна.

Аудитаар нийт 2,324.2 сая төгрөгийн 37 зөрчил илрүүлж, 3.7 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 229.5 сая төгрөгийн зөрчилд зөрчил арилгах тухай 12 албан шаардлага, 2,091.0 сая төгрөгийн зөрчилд зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллах талаар 24 зөвлөмжийг тус тус холбогдох албан тушаалтнуудад хүргүүлэв.

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ УЛАМЖЛАХ НЬ:

1. Монгол Улсын 2024 оны төсвийн тухай хуулиар 42,708.1 сая төгрөг баталснаас Сангийн яамнаас Дорноговь аймагт ОНХНС-аас олгох шилжүүлгийг 40,852.2 сая төгрөг шилжүүлж, 1,855.9 сая төгрөгөөр дутуу олгосон байгаа нь ОНХС-аар төлөвлөсөн ажил бүрэн хэрэгжихгүй байх эрсдэл үүсгэсэн байна. Иймд ОНХНС-аас олгох орлогын шилжүүлгийг хуваарийн дагуу, хугацаанд нь бүрэн олгож байх асуудлыг СЯ-д уламжлах
2. Засгийн газрын 2010 оны “Жишиг хэмжээг шинэчлэн тогтоох тухай” (наадмын санхүүжилт) 271 дүгээр тогтоолын Үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тогтоосон. Уг тогтоол 15 жилийн өмнө батлагдсан бөгөөд аудитаар тус тогтоолыг зөрчсөн зөрчил жил бүр гарч байгаа тул баяр наадмын зардалд гаргах аймаг, сумын жишиг дээд хэмжээг шинэчлэн батлах талаар ЗГ-т уламжлах.

ЗӨВЛӨМЖ:

АЙМГИЙН ЗАСАГ ДАРГАД

1. Аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төсвийг боловсруулахдаа мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг тооцон төлөвлөх.

АЛТАНШИРЭЭ, ӨРГӨН СУМДЫН ЗАСАГ ДАРГАД

1. Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-ний батлагдсан төсөв, санхүүжилт, гэрээний дүн, зарцуулалт, иргэдийн санал, гүйцэтгэлийн хувь, зураг гэх мэт мэдээллийг удирдлага мэдээллийн системд иж бүрэн, цаг тухай бүрд мэдээлэн, системийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

ДАЛАНЖАРГАЛАН, ИХХЭТ, САЙНШАНД СУМДЫН ИТХ-ЫН ДАРГАД

1. Төсвийн Төсвийн тухай хуулийн 29.4, 60.3.6-д тус тус заасны зураг төсөв, техник эдийн засгийн үндэслэлгүй, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ТАХ-г батлахгүй байх

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төсвийг боловсруулахдаа өмнө оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлд үндэслэн үнэн зөв тооцон төлөвлөх.
2. ОНХС- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд, журамд заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн тусган аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлэх.
3. Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-ний батлагдсан төсөв, санхүүжилт, гэрээний дүн, зарцуулалт, иргэдийн санал, гүйцэтгэлийн хувь, зураг гэх мэт мэдээллийг удирдлага мэдээллийн системд иж бүрэн, цаг тухай бүрд мэдээлэн, системийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

ДЭЛГЭРЭХ СУМЫН ИТХ-ЫН ДАРГАД

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн хувь, чанар, үр дүн зэрэгт дүн шинжилгээ хийж, шийдвэрлэн нотлох баримтаар баталгаажуулан ажиллах.

ИХХЭТ СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төсвийг боловсруулахдаа өмнө оны үлдэгдлээс санхүүжих эх үүсвэрийг мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэлд үндэслэн үнэн зөв тооцон төлөвлөх.
2. ОНХС- Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-ний батлагдсан төсөв, санхүүжилт, гэрээний дүн, зарцуулалт, иргэдийн санал, гүйцэтгэлийн хувь, зураг гэх мэт мэдээллийг удирдлага мэдээллийн системд иж бүрэн, цаг тухай бүрд мэдээлэн, системийн хэрэгжилтийг хангаж ажиллах.

МАНДАХ, ХАТАНБУЛАГ СУМДЫН ЗАСАГ ДАРГАД

1. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д заасны дагуу иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ТАХ-г батлахгүй байх

САЙХАНДУЛААН СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Сумын ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ТАХ-ний төсвийг боловсруулахдаа аймгийн ИТХ-аар хуваарилан баталсан сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгээс нэмэгдүүлэн төсвийг батлахгүй байх

УЛААНБАДРАХ, ХАТАНБУЛАГ СУМДЫН ЗАСАГ ДАРГАД

1. ОНХС-ийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд, журамд заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн тусган аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлэх.

ХӨВСГӨЛ СУМЫН ИТХ-ЫН ДАРГАД

1. ОНХС- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжиж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр, ТАХ-ний хэрэгжилтэд хяналт тавьж, гүйцэтгэлийн хувь, чанар, үр дүн зэрэгт дүн шинжилгээ хийж, шийдвэрлэн нотлох баримтаар баталгаажуулан ажиллах.

ХӨВСГӨЛ СУМЫН ЗАСАГ ДАРГАД

1. Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.6-д заасны дагуу иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй ТАХ-г батлахгүй байх
2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд, журамд заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн тусган аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлэх.

САЙНШАНД, ЗАМЫН-ҮҮД СУМДЫН ЗАСАГ ДАРГАД

1. ОНХС- ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжсэн ТАХ-ний хэрэгжилтийн тайланг хуулийн хугацаанд, журамд заасан мэдээллийг үнэн зөв, иж бүрэн тусган аймгийн ЗДТГ-ын ХОХБТХ-т хүргүүлэх.
2. ОНХС Аймаг, сумдын ИТХ-аар батлагдсан ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ТАХ-ний батлагдсан төсөв, санхүүжилт, гэрээний дүн, зарцуулалт, иргэдийн санал, гүйцэтгэлийн хувь, зураг гэх мэт мэдээллийг удирдлага мэдээллийн системд иж бүрэн, цаг тухай бүрд мэдээлэн, системийн хэрэгжилтийг хангаж ажиллах.